**Монгол улсын хууль**

# Тусгай хамгаалалттай газар нутгийн “***Орчны Бүсийн тухай хуулиас***”

1997 оны 10 дугаар сарын 23-ны өдөр
Улаанбаатар хот

# Орчны бүсийг тогтоох шалгуур /4.1/

## Экологийн шалгуур 4.1.1

*Онцгой ач холбогдол бүхий биологийн төрөл зүйл, нэн ховор, ховор ан амьтны байршил, нутагшилт, цаашид нутагшиж болох газар, тархац, тэдгээрийн нүүдлийн зам, гол, голын эх сав газар*

## Нийгэм эдийн засгийн шалгуур 4.1.2

*-тухайн тусгай хамгаалалттай газраас байгалийн баялаг ашиглан орлого олдог нутгийн иргэдийн амьдардаг газар нутаг;*

*-байгаль орчныг бохирдуулах эх үүсвэрийн байршил, нөлөөллийн хүрээ;*

*-нутгийн хүн ам, айл өрх, малын нягтрал нь бэлчээрийн даац, усны хангамжийн хүрэлцээнд сөрөг нөлөө үзүүлж байгаа газар нутаг;*

*-нийгэм, эдийн засгийн хөгжил нь тухайн тусгай хамгаалалттай газар, түүний орчны байгаль, байгалийн нөөцөөс онцгой хамаарал бүхий суурин.*

## Бусад шалгуур 4.1.3

*-байгалийн өвөрмөц тогтоц, онцлог бүхий газар нутаг*

*-түүх, соёлын дурсгалт зүйлс бүхий газар нутаг*

# Орчны бүсийн хил заагийг тогтоох /5/

- Хамгаалалтын захиргаа ⇄ Засаг Дарга
- Иргэдэд мэдээлэл өгөх, санал авах, тус хуулийг сурталчлах
- Шалгуурын дагуу мэдээлэл цуглуулж байгалийн нөөцийг 1:500000 зурагт тусгана

- Хамгаалалтын захиргаа /ХЗ/ ⇄ Орчны бүсийн зөвлөл /ОБЗ/
- **Зааг тогтоох санал боловсруулна**
- Засаг даргад өргөн барина
- ИТХ –аар хэлэлцэнэ
- Тухайн газрыг Тусгай хамгаалалтад авснаас хойш 1 жилийн дотор орчны бүсийн хилийн заагийг БОЯ -аас батална

## Орчны бүсийн зөвлөл /ОБЗ/ /6/

**Бүрэлдэхүүн**

- Сумын ИХТ-өөс 2-өөс доошгүй төлөөлөгч
- Нутгийн Иргэдээс 3-аас доошгүй
- ХЗ –аас 2 төлөөлөгч
- ТББ-ийн төлөөлөгч байж болно

### Зөвлөлийн эрх үүрэг

- Хуулийн хэрэгжилтэд хяналт тавина
- **Менежментийн төлөвлөгөө боловсруулна**
  - *ЗД+ХЗ+ОБЗ төлөвлөгөөг боловсруулна*
- **Санг зохицуулах / хуваарилах, арвижуулах**/ **хяналт тавих/**
  - Хандивууд, үйлчилгээний тодорхой хэсгээс бүрдэнэ
    - *ОБ-ийг хөгжүүлэх*
    - *Иргэдийн амьжиргааг дээшлүүлэх*
- Иргэдийг мэдээллээр хангах, хууль сурталчлах

## Орчны бүсийн сангийн зарцуулалт /7/

- Нөхөн сэргээлт
- Иргэдийн амьжиргааг дээшлүүлэх- ЖДҮ хөгжүүлэх, төсөл хэрэгжүүлэх
- Байгаль орчинд халтай технологийг шинэчлэх
- Байгалийн гамшгийн хохирлыг арилгах

## ОБ-ийн хууль тогтоомжид хяналт тавих /10/

ИТХ → ОБ-ийн үйл ажиллагаа болон хууль тогтоомжид хяналт тавина ← БОЯ

Иргэд аж ахуйн нэгж ОБ-ийн хамгаалалт болон хуулийн хэрэгжилтийн талаарх гомдлоо БО-ны байцаагч, ЗД-д гаргаад эс зөвшөөрвөл

↓

Шүүхэд хандах эрхтэй

Хуулинд орсон зарим нэр томъёоны хураангуй:

| | |
|---|---|
| **Орчны бүс** | *Дархан цаазат болон байгалийн цогцолборт газарт үзүүлж байгаа буюу үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг багасгах, арилгах, урьдчилан сэргийлэх, тухайн газар нутгийг хамгаалахад иргэдийн оролцоог өргөжүүлэх, тэдний ахуй амьдралаа баталгаажуулах, байгалийн баялгийг зохистой ашиглах шаардлагыг харгалзан тогтоосон газар нутгийг орчны бүс гэнэ.* |
| **Тусгай хамгаалалттай газар нутаг** | *Тухайн газар нутаг дахь биологийн төрөл зүйл, байгалийн нөөц, баялаг болон түүх соёлын дурсгалт зүйлсийг зөв зохистой ашиглах хамгаалах асуудал нь тусгайлан гаргасан хууль тогтоомж ба менежментийн үр ашигтай зохион байгуулалтаар зохицуулагдаж буй газар нутгийг Тусгай Хамгаалалттай Газар Нутаг гэнэ.* |
| **Байгалийн цогцолборт газар** | *Хүн амын амралт, аялал жуулчлалыг зөв зохион байгуулах үүднээс байгуулагдсан, экологи, түүх, газарзүйн хувьд онцгой ач холбогдолтой, аж ахуйн ашиглалтаас чөлөөлж, улсын хамгаалалтад авсан нутаг* |
| **Биологийн төрөл зүйл** | *Байгаль дээрх бүх амьд организм, ургамал, амьтан, бичил биетэн тэдгээрийн төрөл зүйл, удамшлийн нэгдлийг хэлнэ* |